



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 1/436

Мандалговь

Г  
Мандал шилтгээн ХХК-тай нэмэлт  
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 34 дугаар зүйлийн 34.2, 34.1.4 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх “Сургуулийн спорт талбайн тоглоомын тохижилт (Сайнцагаан сум ГИЦС)” ХХК-тай байгуулсан БСШУСЯ/201902246-ны дугаартай 178,190,040 (нэг зуун далан найман сая нэг зуун ерэн мянга дөчин төгрөг) төгрөгийн гэрээний дүнг 21,679,368 (хорин нэгэн сая зургаан зуун далан есөн мянга гурван зуун жаран найм) төгрөгөөр нэмэлт гэрээ байгуулсугай.

Хоёр. Нэмэлт батлагдсан зураг төсвийн дагуу “Сургуулийн спорт талбайн тоглоомын тохижилт (Сайнцагаан сум ГИЦС)”-ыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Мандал шилтгээн” ХХК-ны захирал (Б.Ням)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай нэмэлт гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнсүрэн), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488191260